



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/1278

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлэгдсэн нийт 238,845,324.64 (хоёр зуун гучин найман сая найман зуун дөчин таван мянга гурван зуун хорин дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар (Т.Дамбийням)-т, Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо “Уясах” өрхийн эрүүл мэндийн төв (У.Мөнхзул)-д, 21 дүгээр хороо “Дуут жинст” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Сарантуяа)-д тус, тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205609

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 11 сарын 04 өдрийн
 16/12/28 захирамжийн
 хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Суудлын автомашин	Toyota. Prius Alpha-XW	ZVW413220906	74-52 УЕО	2015	2024	39,820,000.0	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүрэг 8-р хороо "Уясах" өрхийн эрүүл мэндийн төв
2	Суудлын автомашин	Toyota. Prius Alpha-XW	ZVW410051938	48-32 УЕН	2016	2024	39,820,000.0	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүрэг 21-р хороо "Дуут жинст" өрхийн эрүүл мэндийн төв
3	Суудлын автомашин	KIA.Rio-YB17	KNADB514BN6584036	16-76 УАТ	2021	2024	39,801,331.16	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар
4	Суудлын автомашин	KIA.Rio-YB17	KNADB514BN6585586	24-16 УАТ	2021	2024	39,801,331.16	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар
5	Суудлын автомашин	KIA.Rio-YB17	KNADB514BN6585774	23-90 УАТ	2021	2024	39,801,331.16	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар
6	Суудлын автомашин	KIA.Rio-YB17	KNADB514BN6583817	69-43 УАТ	2021	2024	39,801,331.16	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар
Нийт дүн							238,845,324.64		